

БАТЛАВ: ЭРДЭНЭБҮРЭНГИЙН
УСАН ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН
“ХӨРСНИЙ МИКРОБИОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ”-ЫН ДААЛГАВАР

2024 оны 09 сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Үндэслэл:

Төслийн нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн Өмнөговь сумын 125 айл өрх, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 айл өрхийн нүүлгэн шилжүүлэлтээс үүсэх хөрсний гадаргын микробиологийн бохирдлын түвшин усан сан үүсгэн усыг хуримтлуулахад сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг тодорхойлох;

Ажлын даалгавар:

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн 2021 онд батлагдсан БОННУ тайланг үндэслэн хөрсний микробиологийн судалгааг хийж гүйцэтгэх;

Захиалагч байгууллага	ЭБУЦСтанц
Ажлын зорилго:	<p>Гүйцэтгэгч нь ажлын төлөвлөгөө, захиалагч талын өгсөн чиглэл зааварчилгаа болон байгаль орчны стандарт, дүрэм, журам, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн Өмнөговь сумын 125 айл өрх, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 айл өрхийн өвөлжөө, хаваржааны микробиологийн бохирдлын судалгааны ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>Хээрийн судалгааг хийхээс өмнө 2 талын хооронд байгуулах гэрээ, хээрийн судалгаа болон нийт зардлын тооцоо, хээрийн судалгааны дэлгэрэнгүй төлөвлөгөө, төсвийн тооцооллыг “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төсөл хэрэгжүүлэгч нэгжид гүйцэтгэгч тал хүлээлгэн өгнө.</p>

Ажил гүйцэтгэх хугацаа:	Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх хугацаа Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй гэрээ байгуулснаас хойш 45 хоног байна.
Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	<p>Хөрс судлаач - Байгаль орчны мэргэжилтэн</p> <ul style="list-style-type: none"> • Судалгааны ажлыг хувь хүн болон байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий аж ахуй нэгж гүйцэтгэх боломжтой; • Хүрээлэн буй орчин судлал, Хөрс судлаач, бусад Байгаль орчны чиглэлийн мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх; • Хөрс судлалын чиглэлээр мэргэшсэн, ажлын даалгаварт заагдсан чиглэлээр 5 жил ажилласан туршлагатай байх;
Гүйцэтгэх ажил	<p>Судалгааны ажлыг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн шинжлэх ухааны арга зүйн дагуу хийж гүйцэтгэнэ. Төслийн талбайд хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхдээ хөрсний одоогийн бохирдлын түвшин шинээр үүсэх усан санд хэрхэн нөлөөлөхийг тогтоож зөвлөмж боловсруулна.</p> <p>“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн 2021 онд батлагдсан БОННУ тайланг үндэслэн Увс аймгийн Өмнөговь сумын 125 өрх, Баян-Өлгий амгийн Баяннуур сумын 145 айл өрхийн микробиологийн судалгааг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Увс аймгийн Өмнөговь сумын 125 айл өрхийн микробиологийн дээж авч буй координатын цэг, байршилыг фото зургаар баримтжуулан, тайланд оруулах; • Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 айл өрхийн дээж авч буй координатын цэг, байршилыг фото зургаар баримтжуулан, тайланд оруулах; • Микробиологийн дээжийг Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлэх; • Микробиологийн дээжний хариунд үндэслэн тайланг бүрэн хэмжээнд хийж гүйцэтгэх; • Микробиологийн дээж авсан байршилыг агаар сансрын зургаар харуулах, үр дүнг тус зургаар тайлагнан хавсаргах; • Микробиологийн бохирдол хэр түвшинд байгааг тодорхойлж, үнэлэлт өгөх, дүгнэлт хийх, цаашид

	<p>хэрэгжүүлэх арга хэмжээг зардал өртгийн хамт тайланд дэлгэрэнгүй тусгах;</p> <ul style="list-style-type: none"> • Микробиологийн дээжинд шинжилгээ хийлгэсэн баримтыг тайланд хавсаргах;
Ажлын тайлан хүргүүлэх	<p>Тайланг бэлтгэхдээ тоон мэдээ, байрзүйн дэвсгэр зураг зэргийг хавсарган монгол хэлээр нэг хувь хэвлэмэл, цахим (word болон pdf) хэлбэрээр хүлээлгэж өгнө.</p> <p>Тайланг ТУХ (Төслийн удирдах хороо) эсвэл төслийн нэгжид тайлагнана.</p>

Гүйцэтгэгч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Бүрдүүлэх материал:

- Судалгааны ажлыг гүйцэтгэх хүсэлт, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/хуулийн этгээд/, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх, гэрчилгээний хуулбар;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар/багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);

Ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.